

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3-4
2. Аудитын тайлан	5
2.1 Оршил	5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагааны, хууль, эрх зүйн орчин	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11 Шилэн дансны мэдээлэл	9
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
3.1 Хөрөнгийн талаар	11
3.1.1 Илрүүлэлт:	11
3.1.2 Эрсдэл:	11
3.1.3 Өгсөн зөвлөмж:	11
3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	11
3.2 Бараа материалын талаар	12
3.2.1 Илрүүлэлт:	12
3.2.2 Эрсдэл:	12
3.2.3 Өгсөн зөвлөмж:	12
3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
3.3 Туслах үйл ажиллагааны талаар	12
3.3.1 Илрүүлэлт:	12
3.3.2 Өгсөн зөвлөмж:	12
3.3.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
4. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13-14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15-16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17-18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20-21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн тайлан	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/252
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

"Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал Б.Амартүвшин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний Аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Лидер экаунт аудит" ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

"Шинэ эрин" лаборатори сургууль нь "Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл бүхий хүмүүнлэг Монгол иргэнийг төлөвшүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 179 дүгээр тогтоолоор "Шинэ эрин" лаборатори сургуулийг байгуулж, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын бүрэн дунд боловсролын томоохон шинэчлэл болох олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн Кембрижийн их сургуулийн дэргэдэх Олон улсын Үнэлгээний төвийн гаргадаг сургалтын хөтөлбөр, үнэлгээний нэгдмэл үйлчилгээг Монгол Улс боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж, харилцан судалж хос хэлний хөтөлбөртэй сургуулийг байгуулж, сурагч, багш, сургуулийн оролцдог үнэлгээ, түүний батламж нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, сурагч ирээдүйд эзэмших мэргэжил сонирхолдоо тулгуурлан хичээлээ, хөтөлбөрөө, шалгалтын даалгавраа сонгодог уян хатан сонголт, сургуулийн хөгжил, удирдлага зохион байгуулалт нь шинэлэг бөгөөд судалгаанд тулгуурласан шийдвэртэй гэдгээрээ нэлээдгүй онцлог юм.

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

"Шинэ эрин" лаборатори сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтнийг татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "ACOLOUS" програм хангамж ашигладаг байна.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны нийт зардал 1,117,072.4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 11,170.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үзэх учраас материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр, 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	114,377.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	1	585,975.0	
Дүн		4	700,352.0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулав.

Тус сургууль нь 2018 оны жилийн эцсийн тооллого хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтуудыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдон 2018 онд 895,514.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

"Шинэ эрин" лаборатори сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус сургууль төсвийн орлого, зарлага түүний хэмнэлт хэтрэлтийг сар бүр, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг хуулийн хугацаанд оруулж ирсэн байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар түрээсийн төлбөртэй холбоотой төлбөрийн акт тогтоож, авлага, хөрөнгийн тооллого, нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой асуудлаар 3 зөвлөмжийг тус тус өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид "Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Шинэ эрин" лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Шинэ эрин" лаборатори сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгийн талаар

3.1.1. Илрүүлэлт:

Одоо ашиглагдаж байгаа элэгдлийн зардлаа нөхөж дууссан 60,800.0 төгрөгийн үнэтэй County маркийн автобусыг дахин үнэлж, эдийн засгийн ашиглалтын хугацааг тооцож, цаашид бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлээгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Уг асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Бараа материалын талаар

3.1.1. Илрүүлэлт:

Тусгай зориулалттай бараа материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй нийт 37 нэр төрлийн, 49,577.0 мянган төгрөгийн хөрөнгийг дансны ангилал буруу бүртгэсэн байна.

3.1.2. Эрсдэл:

Стандарт, хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартын дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэх. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Туслах үйл ажиллагааны орлогын талаар

3.1.1. Илрүүлэлт:

Тус сургуулийн 2018 оны батлагдсан төсөвт туслах үйл ажиллагааны орлогоор 4,000.0 мянгөн төгрөг тусгагдсан байна. Кембрижийн олон улсын шалгалтын стандартын дагуу явагддаг элсэлтийн шалгалтын зардлын хэмжээ, зарцуулалтыг сургуулийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэдэг бөгөөд шалгалтын хураамжийг нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулж, шалгалтын үйл ажиллагаанд зарцуулж ирсэн байна.

Сургуулийн удирдлага шалгалтын хураамжийн орлогыг шалгалтын үйл ажиллагаанд зарцуулах зориулалттайгаас бус төсвийн орлого бүрдүүлэх орлого биш гэж тайлбарлаж байна.

3.1.2. Өгсөн зөвлөмж:

Уг асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд тавьж шийдвэрлүүлэх. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

3.1.3. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>104,288,458.63</u>	<u>116,833,239.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31110	Төгрөг		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
3121	Төгрөг		
33	АВЛАГА	831,751.33	279,686.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	
335	Бусад авлага	531,751.33	279,686.86
3351	Байгууллагаас авах авлага	531,751.33	279,686.86
35	БАРАА МАТЕРИАЛ	103,456,707.30	116,553,552.90
351	Түүхий эд материал	56,113,373.50	62,353,417.50
35110	Тусгай зориулалттай материал	56,113,373.50	62,353,417.50
354	Хангамжийн материал	47,343,333.80	54,200,135.40
35410	Бичиг хэргийн материал	1,834,142.00	2,890,196.00
35420	Аж ахуйн материал	36,437,845.00	37,905,093.00
35430	Сэлбэг хэрэгсэл	414,000.00	400,000.00
35440	Түлш, шатах тослох материал	537,173.80	141,044.40
35470	Бусад хангамжийн материал	8,120,173.00	12,863,802.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,318,977,882.25</u>	<u>4,015,515,089.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,318,977,882.25	4,015,515,089.08
392	Биет хөрөнгө	2,314,494,260.38	4,011,946,652.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,049,844,964.00	3,750,560,295.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-149,520,395.81	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,800,000.00	60,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-60,800,000.00	-60,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	407,755,611.87	411,155,611.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-254,862,672.98	-374,172,495.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	469,421,581.06	469,421,581.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-294,777,068.83	-330,235,260.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,800,000.00	4,744,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,639,999.88	
39217	Ном	80,472,240.95	80,472,240.95
393	Биет бус хөрөнгө	4,483,621.87	3,568,436.11
39301	Програм хангамж	48,767,381.74	48,767,381.74
39302	Хуримтлагдсан элэгдэл	-44,283,759.87	-45,198,945.63
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,423,266,340.88</u>	<u>4,132,348,328.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>1,126,009.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,126,009.00
413	Өглөг		1,126,009.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,423,266,340.88</u>	<u>4,131,222,319.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,423,266,340.88	4,131,222,319.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,132,187,517.32	3,132,187,517.32
51101	Өмч: - төрийн	3,132,187,517.32	3,132,187,517.32

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	-708,921,176.44	-885,365,006.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-708,921,176.44	-708,921,176.44
51220	Тайлант үеийн үр дүн		-176,443,830.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,884,399,809.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,423,266,340.88</u>	<u>4,132,348,328.84</u>

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	902,930,067.27	940,628,560.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	767.27	8,160.00
120	Нийтлэг татварын бус орлого	767.27	8,160.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	767.27	8,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	767.27	8,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	902,929,300.00	940,620,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	881,574,800.00	895,514,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	881,574,800.00	895,514,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,354,500.00	45,105,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,627,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,055,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,727,500.00	26,050,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,025,389,487.11	1,116,537,070.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,025,389,487.11	1,116,537,070.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	997,213,956.24	1,111,646,952.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,927,943.13	717,709,944.18
210101	Үндсэн цалин	671,927,943.13	716,209,944.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,108,228.19	84,975,775.05
210201	Тэтгэврийн даатгал	49,728,429.61	84,975,775.05
210202	Тэтгэмжийн даатгал	3,756,310.51	
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,630,242.90	
210204	Ажилгүйдлийн даатгал	3,096,308.03	
210205	Эрүүл мэндийн даатгал	12,896,937.14	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,617,800.13	45,564,908.93
210301	Гэрэл, цахилгаан	18,370,672.00	24,461,526.29
210302	Түлш, халаалт	18,864,780.91	17,713,682.64
210303	Цэвэр, бохир ус	382,347.22	3,389,700.00

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	22,711,904.81	21,814,402.14
210401	Бичиг хэрэг	5,503,185.00	6,639,656.00
210402	Тээвэр, шатахуун	4,194,344.20	4,675,829.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,106,102.21	7,102,490.74
210404	Ном, хэвлэл	307,600.00	186,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600,673.40	3,209,526.00
2105	Нормативт зардал	346,268.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,268.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,484,122.00	6,252,730.00
210604	Урсгал засвар	8,484,122.00	6,252,730.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,885,805.80	20,848,558.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,257,585.80	17,284,408.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	30,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	463,320.00	1,406,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,131,884.18	214,480,634.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,140,703.84	23,753,351.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,991,180.34	190,727,282.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,175,530.87	4,890,117.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,043,900.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,443,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,600,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,131,630.87	4,890,117.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,131,630.87	4,890,117.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-122,459,419.84	-175,908,510.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		535,320.16
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		535,320.16
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-535,320.16
5	НИЙТ ҮР ДҮН	-122,459,419.84	-176,443,830.53

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>932,636,504.27</u>	<u>976,439,491.40</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,161,857.27	23,695,191.40
120	Нийтлэг татварын бус орлого	19,161,857.27	23,695,191.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,161,857.27	23,695,191.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,161,857.27	23,695,191.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913,474,647.00	952,744,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	881,574,800.00	895,514,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	881,574,800.00	895,514,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,354,500.00	45,105,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,627,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,055,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,727,500.00	26,050,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,545,347.00	12,123,900.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,545,347.00	12,123,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>932,081,904.27</u>	<u>976,439,491.40</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	932,081,904.27	976,439,491.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	903,906,373.40	961,791,373.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	682,473,290.13	720,092,730.18
210101	Үндсэн цалин	680,138,290.13	373,886,230.18
210102	Нэмэгдэл		217,895,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		42,310,000.00
210104	Урамшуулал	2,335,000.00	86,000,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,134,628.43	85,229,061.67
210201	Тэтгэврийн даатгал	76,134,628.43	57,928,861.67
210202	Тэтгэмжийн даатгал		6,825,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		5,460,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,365,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал		13,650,100.00

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,617,800.13	44,438,899.93
210301	Гэрэл, цахилгаан	18,370,672.00	23,335,517.29
210302	Түлш, халаалт	18,864,780.91	17,713,682.64
210303	Цэвэр, бохир ус	382,347.22	3,389,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,331,337.21	23,165,841.74
210401	Бичиг хэрэг	5,821,590.00	7,699,810.00
210402	Тээвэр, шатахуун	4,656,100.00	4,279,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,585,433.21	7,102,490.74
210404	Ном, хэвлэл	367,600.00	186,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,900,614.00	3,896,941.00
2105	Нормативт зардал	791,554.00	271,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	791,554.00	271,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,323,200.00	9,614,330.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,400,000.00
210604	Урсгал засвар	8,323,200.00	6,214,330.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,866,285.80	26,044,248.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,365,185.80	19,237,748.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	30,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,336,200.00	4,648,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,368,277.70	52,935,262.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,140,090.00	23,016,399.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,228,187.70	29,918,862.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,175,530.87	14,648,117.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,043,900.00	9,758,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,443,900.00	9,758,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,600,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,131,630.87	4,890,117.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,131,630.87	4,890,117.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>554,600.00</u>	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	554,600.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	554,600.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	554,600.00	

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	554,600.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-554,600.00</u>	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,132,187,517.32		-586,461,756.60	2,545,725,760.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32		-586,461,756.60	2,545,725,760.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн			-122,459,419.84	-122,459,419.84
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				2,423,266,340.88
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,132,187,517.32		-708,921,176.44	2,423,266,340.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32		-708,921,176.44	2,423,266,340.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,884,399,809.49		1,884,399,809.49
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			-176,443,830.53	-176,443,830.53
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	-885,365,006.97	4,131,222,319.84

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	895,514,900.00	895,514,900.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	895,514,900.00	895,514,900.00		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,756,900.00	885,001,790.25	-755,109.75	-0.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686,504,800.00	686,330,601.18	-174,198.82	-0.03
210101	Үндсэн цалин	341,798,300.00	341,624,101.18	-174,198.82	-0.05
210102	Нэмэгдэл	217,895,700.00	217,895,700.00		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,810,000.00	40,810,000.00		
210104	Урамшуулал	86,000,800.00	86,000,800.00		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,275,600.00	82,857,098.67	-418,501.33	-0.51
210201	Тэтгэврийн даатгал	55,975,400.00	55,556,898.67	-418,501.33	-0.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,825,000.00	6,825,000.00		
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,460,100.00	5,460,100.00		
210204	Ажилгүйдлийн даатгал	1,365,000.00	1,365,000.00		
210205	Эрүүл мэндийн даатгал	13,650,100.00	13,650,100.00		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,438,900.00	44,438,899.93	-00.07	
210301	Гэрэл, цахилгаан	17,697,500.00	23,335,517.29	5,638,017.29	24.16
210302	Түлш, халаалт	23,351,700.00	17,713,682.64	-5,638,017.36	-31.83
210303	Цэвэр, бохир ус	3,389,700.00	3,389,700.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	22,828,400.00	19,673,884.74	-3,154,515.26	-16.03
210401	Бичиг хэрэг	4,208,400.00	4,728,860.00	520,460.00	11.01
210402	Тээвэр, шатахуун	7,481,000.00	4,199,700.00	-3,281,300.00	-78.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,954,300.00	7,102,490.74	-2,851,809.26	-40.15
210404	Ном, хэвлэл	249,400.00	186,900.00	-62,500.00	-33.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	935,300.00	3,455,934.00	2,520,634.00	72.94
2105	Нормативт зардал	808,500.00	271,000.00	-537,500.00	- 198.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-184,200.00	271,000.00	455,200.00	167.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,214,600.00	6,214,330.00	-270.00	
210604	Урсгал засвар	6,214,600.00	6,214,330.00	-270.00	

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,286,700.00	15,305,273.00	1,018,573.00	6.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,609,400.00	10,856,773.00	2,247,373.00	20.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00	-4,500.00	-3.53
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,800.00	30,500.00	-24,300.00	-79.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,490,600.00	2,290,600.00	-1,200,000.00	-52.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,399,400.00	29,910,702.73	2,511,302.73	8.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,399,400.00	29,910,702.73	2,511,302.73	8.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,758,000.00	10,513,109.75	755,109.75	7.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,758,000.00	9,758,000.00		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,758,000.00	9,758,000.00		
	Олгосон санхүүжилт шилжүүлэг		755,109.75	755,109.75	100.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		755,109.75	755,109.75	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	895,514,900.00	896,185,532.09	670,632.09	0.07
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	891,514,900.00	895,514,900.00	4,000,000.00	0.45
131001	Улсын төсвөөс санхүүжих	891,514,900.00	895,514,900.00	4,000,000.00	0.45
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000.00		-4,000,000.00	- 100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00		-4,000,000.00	- 100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53	53		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	40	40		
620003	Үйлчлэх ажилтан	12			

“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Шинэ эрин” лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.22			САГ-2019/29/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		“Шинэ эрин” лаборатори сургууль	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	9	10
1	Авто тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй County маркын автобус элэгдлийн зардлаа нөхөж, үлдэгдэл өртөг нь тэг болсон. Хөрөнгө хэвийн ажиллагаатай, ашиглалтанд байгаа.	60,800.0	Зөвлөмж	Захирал	Б.Амартүвшин
				Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ
2	2018 оны төсөвт Туслах үйл ажиллагааны орлого 4 сая төгрөг батлагдсаныг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй.	4,000.0	Зөвлөмж	Захирал	Б.Амартүвшин
				Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ
3	Тусгай зориулалттай бараа материал, аж ахуйн материал, бусад хангамжийн матриал дансанд нийт 37 нэр төрлийн барааны дансны ангилал тохирохгүй байна.	49,577.0	Зөвлөмж	Захирал	Б.Амартүвшин
				Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ
4	2018 оны жилийн эцсийн тооллого хийгээгүй.	585,975.0	Албан шаардлага	Захирал	Б.Амартүвшин
				Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ
Дүн		700,352.0			

